



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН  
ХОРОО



# 2018

## БАРИЛГЫН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА

Барилгын салбарын танилцуулгатай холбоотой мэдээлэл, санал, хүсэлтээ доорх хаягаар илгээнэ үү.

---

### Үндэсний Статистикийн Хороо

**Хаяг:** Засгийн газрын III байр,  
Бага тойруу - 44, Улаанбаатар -11  
Монгол улс

**Вэб хуудас:** [www.nso.mn](http://www.nso.mn), [www.1212.mn](http://www.1212.mn)

### Олон нийттэй харилцах хэлтэс

**Онлайн:** <http://web.nso.mn/onlinechat/index.php>

**Утас:** 1900-1212

### Танилцуулгыг бэлтгэсэн:

ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газрын статистикч Д.Баасан

И-мэйл: [baasan@nso.mn](mailto:baasan@nso.mn)

Утас: 51-261563

### Танилцуулгыг хянасан:

Эдийн засгийн статистикийн газрын дарга Э.Эрдэнэсан

Эдийн засгийн статистикийн газрын ахлах статистикч М.Оюунжаргал

## АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	4
Өмнөх үг.....	5
I. Барилгын салбарын хамрах хүрээ, ойлголт, тодорхойлолт.....	8
II. Монгол Улсад барилгын салбарын эзлэх байр суурь.....	14
III. Ашиглалтад оруулсан үндсэн фонд.....	29
IV. Барилгын зарим нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт.....	36
V. Барилгын салбарын ажиллагчдын тоо, дундаж цалин, хөдөлмөрийн бүтээмж.....	41
VI. Орон сууцны үнэ, ипотекийн зээл.....	46
VII. Барилгын салбарын дэлхийн хөгжлийн чиг хандлага.....	54
Дүгнэлт.....	58
Ашигласан материалын жагсаалт.....	59

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БР	Статистикийн бизнес регистрийн сан
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ЗТХЯ	Зам тээврийн хөгжлийн яам
БХТ	Барилгын хөгжлийн төв
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
АХБ	Азийн Хөгжлийн Банк
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ТЕГ	Татварын Ерөнхий Газар
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
МИК	Монголын Ипотекийн Корпорац
ЗГОСИЗХ	Засгийн газрын орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр
ЭЗБТУАСА	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал

### Тэмдэглэгээ

*	Урьдчилсан гүйцэтгэл
м <sup>2</sup>	Метр квадрат
м <sup>3</sup>	Метр куб
...	Гүйцэтгэл байхгүй

### Тайлбар

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 онд гаргасан уриалга болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс батлан гаргасан “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”-ийг удирдлага болгон гадаад үг хэллэг болон эргэлзээтэй бичигддэг зарим үгийг бичсэн болно.

## ӨМНӨХ ҮГ

ҮСХ нь барилгын салбарын албан ёсны статистикийн мэдээ, тайланг аж ахуйн нэгж, байгууллагаас аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсээр дамжуулан цуглуулж, БХБЯ, БХТ, ЗТХЯ, МХЕГ зэрэг төрийн байгууллагуудын захиргааны статистик мэдээлэлтэй уялдуулан шалгаж, барилгын салбарт гарч байгаа өөрчлөлтийг тухай бүрт тусгасан маягт, зааврын дагуу мэдээллийг цуглуулж ирсэн.

Мөн барилгын салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр буюу ДНБ-д эзлэх хувь, нэмэгдэл өртгийн тооцоог албан болон албан бус сектороор тооцон гаргаж байна.

Салбарын албан секторт ҮСХ-ны бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг, харин албан бус секторт хувиараа барилга угсралт, их засварын үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн үйл ажиллагааг хамруулж байна.

Монгол Улсын барилгын салбарт 2018 онд 12.1 мянган ААНБ үйл ажиллагаа явуулж 67.8 мянган хүн ажиллаж, 1.2 их наяд төгрөгийн нэмэгдэл өртгийг бий болгосон байна. Мөн Монгол Улсын ДНБ-ий 3.6 хувийг дангаараа бүрдүүлж байна.

Энэ удаагийн танилцуулгад 2018 оны барилгын салбарын үзүүлэлтүүдийг өмнөх 10 жил (2008 он), өмнөх 5 жил (2013 он), өмнөх он (2017)-той харьцуулан дараах 7 бүлгийн хүрээнд хийхийг зорилоо. Үүнд:

1. Барилгын салбарын хамрах хүрээ, ойлголт, тодорхойлолт
2. Монгол Улсад барилгын салбарын эзлэх байр суурь
3. Ашиглалтад оруулсан үндсэн фонд
4. Барилгын зарим нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт
5. Барилгын салбарын ажиллагчдын тоо, дундаж цалин, хөдөлмөрийн бүтээмж
6. Орон сууцны үнэ, ипотекийн зээл
7. Барилгын салбарын дэлхийн хөгжлийн чиг хандлага

## Барилгын салбарын хөгжиж ирсэн түүх

**А**рдын хувьсгал ялж, 1924 онд анхны үндсэн хуулиа батлан Бүгд Найрамдах Монгол Ард Улс хэмээн Улсын нийслэлийг Улаанбаатар гэж нэрлэсэн билээ. Үүнтэй уялдуулан эдэлбэр газрыг 104 га байхаар тогтоон Хиагт, Ховд, Улиастай зэрэг сууринг Монгол Улсын хот болгон бусад 115 хүрээ сууринд аймаг, сумын засаг захиргаа, соёлын асуудлыг төвлөрүүлэх тогтоол гаргасан нь дэлхийн соёл иргэншлийн нэг хэлбэр болох суурьшмал хот, суурин байгуулах үзэл баримтлалын анхны үр хөврөл, хууль эрх зүйн баримт бичиг болж түүхэнд үлдсэн билээ.

Барилга угсралтын үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд 1920-иод оны дунд үеэс хөрөнгө оруулалт, барилга угсралтын ажлын бүртгэлийг өөрийн онцлог байдлыг харгалзан бий болгож, хөтөлж эхэлсэн байна. Барилга, байгууламж тоног төхөөрөмжийн тооллогыг 1926, 1927, 1930 онд хүн ам, малын тооллоготой хамт явуулж байжээ. Хошуу, жасын үл хөдлөх хөрөнгийн 1926 оны тооллогоор 30 гаруй мянган орон байшин тоологдсон байна. Монголын хувь нийлүүлсэн барилгын хоршоо, хувь нийлүүлсэн “Монгол транс” нийгэмлэгийн харьяанд 1926 онд зам, барилгын ажлыг гүйцэтгэх ерөнхий газар, мал аж ахуйн яамны дэргэд 1929 онд худаг усны хайгуул, барилгын ажлыг эрхэлсэн усан хангамжийн салбар, аж үйлдвэр, барилгын яамны харьяанд 1938 онд барилгын үйлдвэрлэлийг эрхлэн гүйцэтгэх трест, мөн аж ахуйн аргаар барилгын ажил гүйцэтгэгч, захиалагчийн газар 1937 онд байгуулагдсанаар эдгээр салбарт барилгын статистикийн нэгж бий болсон байна. Барилгын салбарын статистик мэдээллийг 1940-өөд оны сүүлчээс 1959 он хүртэл хөрөнгө оруулалт, барилга угсралт гэсэн төрлөөр тухайн үеийн мөнгөн тэмдэгтээр, үнийн дүнгээр тооцож, төлөвлөгөөний биелэлтийг дүгнэн, хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажлыг захиалагч, гүйцэтгэгч байгууллагаар бүлэглэн гаргаж байжээ. Ялангуяа объект бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, барилгын ажлын түвшинг сар, улирал, жилээр тодорхойлж, төлөвлөгөөний биелэлтийг тогтмол хугацаагаар дүгнэдэг байх үүргийг гүйцэтгэж байжээ. 1960-аад оноос эхлэн барилгын бүртгэлийн ажилд ахиц гарч, барилгын захиалагч, гүйцэтгэгч, зураг төсвийн байгууллагын төлөвлөгөөт зорилтын биелэлтэд тогтмол хяналт тавих, программын үндсэн дээр зохион байгуулалттай статистик ажиглалтыг явуулах бололцоо, нөхцөл бүрджээ. Тоо бүртгэлийн улсын төв газраас Барилгын мэдээ, тайлангийн маягт, зааврыг 1960 онд шинэчлэн боловсруулж, мөрдүүлж эхэлсэн байна.

БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1961 оны 636 дугаар тогтоолоор барилгын байгууллагын улсын чанартай тайлан мэдээг яам, тусгай газрууд өөрийн системээр нэгтгэж, Тоо бүртгэлийн улсын төв газарт ирүүлж байсан журмыг өөрчлөн, аймаг, хотын статистикийн товчоодоор дамжуулан Тоо бүртгэлийн улсын төв газарт мэдээлж байх журам тогтоосноор нэгдсэн системд орсон. Хөрөнгө оруулалт, ашиглалтад оруулах хүчин чадлын үзүүлэлтийг 1970-аад оноос захиалагч яам, аймаг, хот, улс ардын аж ахуйн болон аж үйлдвэр, хөдөө аж ахуйн дэд салбараар бүлэглэн дүгнэж, судалгаа шинжилгээг хийж төрийн бодлогод статистикийн тоо, мэдээг өргөнөөр хэрэглэх болсон байна.

Төр, засгаас 1988 оноос их барилга, хөрөнгө оруулалтын салбарт ихээхэн анхаарал хандуулж, төвлөрсөн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах үүднээс олон тооны нарийвчилсан, дэлгэрэнгүй үзүүлэлтээр мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийдэг байсан. Хөрөнгө оруулалт, ашиглалтад оруулсан үндсэн фондын төлөвлөгөөний биелэлтийн жилийн тайлангаар хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг технологийн бүтцээр, улс ардын аж ахуйн салбараар ангилан гаргаж байв.

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**  
**ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ**



**Барилгын салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт**

УИХ-аас 2016 онд “Барилгын тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан байдаг. Тус хуульд заасан ойлголт, тодорхойлолтыг БХБЯ, барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-уудын хүрээнд мөрдөж байна. Харин “Статистикийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 3.ё хэсэгт “Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ”-г албан ёсны статистикийн мэдээллийн үзүүлэлтэд хамааруулан заасан байдаг. Энэ хуулийн хүрээнд ҮСХ-оос Барилгын салбарын статистикийн мэдээнд дараах ойлголт, тодорхойлолтыг ашиглаж байна. Үүнд:

**ХҮСНЭГТ 1. БАРИЛГЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ, ТОДОРХОЙЛОЛТ**

Үзүүлэлт	Тодорхойлолт
Объект	Бие даасан барилга (орон сууц, үйлдвэрийн гол корпус, сургууль, цех, агуулах), байгууламж (зам, гүүр, далан, суваг, нүхэн гарц) түүнтэй холбогдож хийгдэх үндсэн ба туслах чанарын бусад байгууламж, гадна инженерийн бүх төрлийн шугам сүлжээ, хийц тоноглол, барилгын талбайд хийгдэх өндөржилт, тохижилт болон засварын бүх ажил
Барилга, байгууламж	Орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж, түүний инженерийн шугам сүлжээ
Барилга угсралт, их засварын ажил	Барилга, байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагаа
Орон сууцны барилга	Хүн суурьшин амьдрах зориулалттай, хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг барилга, байгууламж
Орон сууцны бус барилга	Хүн суурьшин амьдрахаас бусад олон төрлийн зориулалтаар баригдах үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, эмнэлэг, сургууль, соёлын болон бусад бүх төрлийн барилга, байгууламж
Инженерийн барилга, байгууламж	Газар доор ба дээр техникийн зориулалттай барьсан зам гүүр, телевизийн цамхаг, өндөр хүчдэлийн, дулааны болон ус дамжуулах шугам, сүлжээ, барилга угсралтад ангилагддаггүй барилга, байгууламжийн бүх төрлийн ажил

## Хамрах хүрээ

Барилгын салбарт ЭЗБҮҮАСА (ISIC 4.0)-ын дагуу барилга угсралт (41), барилгын инженерчлэлийн үйл ажиллагаа (42), барилгын тусгай ажил (43) гэсэн 3 дэд салбарыг хамруулан авч үздэг.

### ХҮСНЭГТ 2. БАРИЛГЫН САЛБАРЫН ХАМРАХ ХҮРЭЭ, (ISIC – 4.0)

Салбар	Дэд салбар	Бүлэг	Анги	Дэд анги	Тодорхойлолт
	<b>41</b>	410	4100		<b>Барилга угсралт</b>
				4100.1	Орон сууцны барилга
				4100.2	Орон сууцны бус барилга
				4100.9	Үйлдвэрийн барилга
	<b>42</b>				<b>Барилгын инженерчлэлийн үйл ажиллагаа</b>
		421	4210		Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа
				4210.1	Авто зам тавих
				4210.2	Төмөр замын суурь бүтэц барих
				4210.3	Төмөр замын далан барих
				4210.4	Гүүр, хоолой/ус зайлуулах суваг, шуудуу барих
				4210.5	Дохиолол төвлөрүүлэх, хориглох байгууламж барих
				4210.6	Төмөр замын дэд бүтэц угсрах
				4210.7	Гүүр, хоолой, хиймэл төхөөрөмж угсрах үйл ажиллагаа
<b>F</b>				4210.9	Дохиолол төвлөрүүлэх, хориглох байгууламж угсрах
		422	4220		Нийтийн аж ахуйн барилга угсралт
		429	4290		Иргэний инженерийн бусад байгууламж үйлдвэрлэл
	<b>43</b>				<b>Барилгын тусгай ажил</b>
		431			Буулгах/нураах ба барилгын талбай бэлтгэх үйл ажиллагаа
			4311		Барилгыг буулгах/нураах үйл ажиллагаа
			4312		Барилгын талбай бэлтгэх үйл ажиллагаа
		432			Цахилгааны тоног төхөөрөмж, ус дамжуулах, сувагжилтын систем угсрах, барилга угсралтын бусад ажил
			4321		Цахилгааны тоног төхөөрөмж, угсралт, суурилуулалт
			4322		Усан хангамж, хийн хангамж, сувагжилт, халаалт, агааржуулагч системийн угсралт
			4329		Барилга угсралтын бусад ажил
		433	4330		Барилгыг дуусгах шатны үйл ажиллагаа
		439	4390		Барилгын бусад тусгай ажил

Эх үүсвэр: <https://metadata.1212.mn/upload/classification/ISIC%204.0%20last.pdf>

*Барилга угсралтын үйл ажиллагаа (41)* нь дотроо 1 анги, 3 дэд ангитай. Үүнд:

Энэ ангид орон сууцны болон орон сууцны бус барилгыг худалдах зорилгоор өөрийн хөрөнгөөр эсвэл гэрээний үндсэн дээр хийж байгаа үйл ажиллагаа болон тухайн барилга, байгууламжийн угсралтын ажлын зарим хэсгийг эсвэл бүхлээр нь гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа хамрагдана. Үүнд:

- ❖ Орон сууцны бүх төрлийн барилга, байгууламж барих үйл ажиллагаа: нэг өрхийн байшин; олон давхар байшинг оруулаад олон өрхийн сууц (4100.1)
- ❖ Орон сууцны бус барилга байгууламжийг барих үйл ажиллагаа: үйлдвэрийн зориулалттай барилга, байгууламж, үйлдвэрийн зориулалттай сургалт, семинар, хурал цуглаан хийх зориулалт бүхий танхим, өрөө, эмнэлэг, сургууль, конторын барилга; зочид буудал, дэлгүүр, худалдааны төв, зах, ресторан; онгоцны буудал спортын байгууламж; газар доорх машины зогсоол; барааны агуулах; шашны зориулалттай барилга, байгууламж, сүм хийд (4100.2)
- ❖ Үйлдвэрийн барилгыг барих, угсрах үйл ажиллагаа (4100.9)

Энэ ангид орон сууцны зориулалт бүхий барилга, байгууламжийг шинэчлэх, сэргээх үйл ажиллагаа бас багтана.

4100.1. Орон сууцны барилга

4100.2. Орон сууцны бус барилга

4100.9. Үйлдвэрийн барилга

*Барилгын инженерчлэлийн үйл ажиллагаа* (42) нь 3 бүлэг (421), (422), (429), 3 анги (4210), (4220), (4290), 8 дэд ангитай.

Энэ дэд салбарт иргэний зориулалттай инженерийн байгууламжууд барих үйл ажиллагаа багтана. Энэ хэсэгт шинэ ажил, засварын ажил, өргөтгөл, шинэчлэл болон түр зуур ашиглагдах зориулалт бүхий барилга байгууламж орно. Үүнд: Моторт тээврийн хэрэгсэлд зориулсан зам, гудамж, гүүр, нүхэн гарц, төмөр зам, агаарын зам, усан боомт болон бусад усны хамгаалалт, далан, усжуулалтын систем, усны шугам сүлжээ, ариутгах татуурга, үйлдвэрлэлийн цогцолбор, дамжуулах хоолой болон цахилгаан шугам, спортын цогцолбор зэрэг барилгууд орно. Энэ ажил нь өөрийн хөрөнгөөр, төлбөр гэрээний үндсэн дээр хийгдэнэ. Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа (421)

4210. Төмөр зам болон авто зам барих үйл ажиллагаа

4210.1. Авто зам тавих

4210.2. Төмөр замын суурь бүтэц барих

4210.3. Төмөр замын далан барих

4210.4. Гүүр, хоолой/ус зайлуулах суваг, шуудуу барих

- 4210.5. Дохиолол, төвлөрүүлэх хориглох байгууламж барих
- 4210.6. Төмөр замын дэд бүтэц угсрах
- 4210.7. Гүүр хоолой, хиймэл төхөөрөмж угсрах үйл ажиллагаа
- 4210.9. Дохиолол төвлөрүүлэх, хориглох байгууламж угсрах
- 422. Нийтийн аж ахуйн барилга угсралт
- 4220. Нийтийн аж ахуйн барилга угсралт
- 429. Барилгын инженерчлэлийн бусад үйл ажиллагаа
- 4290. Барилгын инженерчлэлийн бусад үйл ажиллагаа

*Барилгын тусгай ажил* (43) нь 4 бүлэг (431), (432), (433), (439) 7 ангитай. Үүнд:

Энэ дэд салбарт барилгын тусгай үйл ажиллагаа (тусгай худалдаа), өөрөөр хэлбэл барилга байгууламжийн зарим хэсгийг барих, тухайн төсөлд бүхэлд нь үүрэг хүлээлгүйгээр барилгын инженерийн ажил гүйцэтгэх үйл ажиллагаа орно. Эдгээр үйл ажиллагаа нь суурийн овоолго, суурин ажил, каркасны ажил, бетон зуурмагийн ажил, тоосго өрөх, чулуу шигтгэх зэрэг тусгай ур чадвар, тоног төхөөрөмж шаардсан төрөл бүрийн барилга, байгууламжийн ажилд гол төлөв нийтлэг нэг чиглэлээр төрөлжсөн байдаг.

*431. Буулгах/нураах талбай бэлтгэх үйл ажиллагаа*

4311. Барилгыг буулгах/нураах үйл ажиллагаа

4312. Талбай бэлтгэх үйл ажиллагаа

*432. Цахилгаан тоног төхөөрөмж, ус дамжуулах, сувагжилтын систем угсрах, барилга угсралтын бусад ажил*

4321. Цахилгаан тоног төхөөрөмж угсралт, суурилуулалт

4322. Усан хангамж, хийн хангамж, сувагжилт, халаалт, агааржуулагч, системийн угсралт

4329. Барилга угсралтын бусад ажил

*433. Барилгыг дуусгах шатны үйл ажиллагаа*

4330. Барилгыг дуусгах шатны үйл ажиллагаа

*439. Барилгын тусгай ажил*

4390. Барилгын бусад тусгай ажил

### Мэдээлэл цуглуулах маягт, түүнийг нөхөх заавар

Барилгын салбарт дараах 3 төрлийн мэдээний маягтаар ААНБ-уудаас мэдээллийг цуглуулж байна.

Маягтын нэр	Тушаал
Барилга, байгууламж объектын улирлын мэдээ	ББО-1 ҮСХ-ны даргын 2018 оны А/117 тоот тушаал
ААНБ-ын үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээ	ААНБ-1 ҮСХ-ны даргын 2015 оны 1/161 тоот тушаал
ААНБ-ын үйл ажиллагааны хураангуй мэдээ	ААНБ-2

### Мэдээлэл цуглуулах үндсэн нэгж, урсгал

- Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ нь барилгын мэдээг цуглуулах үндсэн статистикийн нэгж болдог.
- Барилга байгууламж, объектын улирал, жилийн мэдээг ААНБ-аас аймаг, нийслэл (дүүрэг)-ийн статистикийн газар/хэлтэс-т, аймаг, нийслэлийн статистикийн газар/хэлтэс-аас ҮСХ гэсэн урсгалын дагуу цуглуулдаг.

*Барилгын салбарын мэдээний урсгал*



**ХОЁРДУГААР БҮЛЭГ**  
**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ БАРИЛГЫН**  
**САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ**

## БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, 2018 онд



Барилга угсралт  
их засварын ажил  
**4 009.8**  
тэрбум.төг

**3 375.8**  
тэрбум.төг

Дотоодын барилгын  
байгууллагын гүйцэтгэсэн

**634.0**  
тэрбум.төг

Гадаадын барилгын  
байгууллагын гүйцэтгэсэн

## БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр,



Орон сууц

**33.2%**



Орон сууцны бус

**35.9%**



Инженерийн  
байгууламж

**28.5%**



Их засварын  
ажил

**2.4%**

## БАРИЛГЫН САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО

**12 995**

Бүртгэлтэй аж ахуйн  
нэгж, байгууллага



**6 695**

Үйл ажиллагаа явуулж байгаа  
аж ахуйн нэгж, байгууллага

## 2. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ БАРИЛГЫН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

### Аж ахуйн нэгж, байгууллага

Статистикийн бизнес регистрийн санд 2018 оны эцэст нийт 170.2 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 13.0 мянга буюу 7.6 хувь нь барилгын салбарт хамаарч байна.

Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын дүнд барилгын салбарт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь өмнөх оноос 0.2 пунктээр буурсан бол, 2008 оноос 3.7 пункт, 2013 оноос 1.0 пунктээр тус тус өссөн байна.

Тус салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо тасралтгүй өссөн нь төрөөс ипотекийн жилийн 8.0 хувийн хүүтэй зээл, барилгын материалын үнэ, орон сууцны үнэ тогтворжуулах хөтөлбөр гэх мэт хүн амыг орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

### ХҮСНЭГТ 3. БАРИЛГЫН САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО, ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ


Он	Бүртгэлтэй ААНБ	Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ	Эзлэх хувь
2008	2 372	1 313	55.4
2009	2 615	1 067	40.8
2010	3 057	1 452	47.5
2011	4 226	2 831	67.0
2012	5 430	3 135	57.7
2013	6 529	3 541	54.2
2014	8 940	4 770	53.4
2015	10 496	5 390	51.4
2016	11 430	6 074	53.1
2017	12 103	6 345	52.4
2018	12 995	6 695	51.5

Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 6.7 мянган ААНБ-ын 5.6 (83.4%) мянга нь Улаанбаатар хотод, 1.1 (16.6%) мянга нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.




Харин Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын дүнд барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын эзлэх хувь 2008 оноос 4.2 пунктээр, 2013 оноос 1.4 пунктээр өссөн бол өмнөх оноос 0.3 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 1. БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН НИЙТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ




Барилгын салбарт бүртгэлтэй 13.0 мянган ААНБ-аас 6.7 мянга буюу 51.5 хувь нь үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оноос 0.3 (5.5%) мянган ААНБ, 2008 оноос 5.4 (5.1 дахин) мянган ААНБ, 2013 оноос 3.2 (89.1%) мянган ААНБ-аар тус тус нэмэгдсэн байна.

ЗУРАГ 2. БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН БҮСҮҮДЭД ЭЗЛЭХ ХУВЬ



Барилгын салбарын ААНБ-ууд хүн амын төвлөрөл ихтэй хот, суурин газруудад илүү олноор үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, Улаанбаатар хотод 2018 оны жилийн эцсийн байдлаар тус салбарын нийт ААНБ-ын 83.4 хувь нь үйл ажиллагаа явуулж байгаа нь 2008 оноос 7.2 пунктээр, 2013 оноос 2.0 пунктээр, өмнөх оноос 0.6 пунктээр тус тус өссөн байна.

ЗУРАГ 3. БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН ТОО, аймаг, нийслэлээр, 2018 он



Хүн ам олноор төвлөрсөн хот, суурин газрууд болох Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймгуудад барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо бусад аймгуудаас илүү байна.

Харин Сүхбаатар, Дундговь, Говьсүмбэр аймгуудад барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо бусад аймгуудаас бага байна. (Зураг 3)

### Барилгын салбарын нэмэгдэл өртөг

Монгол Улсын ДНБ-ий хэмжээ 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 32.3 их наяд төгрөгт хүрсний 1.2 (3.6%) их наяд төгрөгийг барилгын салбар бүрдүүлж байна. Барилгын салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2008 оноос 1.0 (9.5 дахин) их наяд төгрөгөөр, 2013 оноос 184.6 (18.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 134.5 (13.1%) тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Барилгын салбарын нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь 2018 онд 3.6 хувь байгаа нь 2013 оноос 1.5 пунктээр, өмнөх оноос 0.1 пунктээр тус тус буурч, 2008 оноос 1.7 пунктээр өссөн байна.


ХҮСНЭГТ 4. БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, үйлдвэрлэлийн аргаар

Он	ДНБ, оны үнээр, тэрбум төгрөг	Салбарын нэмэгдэл өртөг, оны үнээр, тэрбум төгрөг	Барилгын салбарын нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь	Салбарын нэмэгдэл өртөг, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төгрөг
2008	6 555.6	122.1	1.9	...
2009	6 590.6	86.2	1.3	...
2010	9 756.6	250.2	2.6	250.2
2011	13 173.8	402.8	3.1	307.0
2012	16 688.4	837.5	5.0	568.8
2013	19 174.2	979.7	5.1	614.2
2014	22 227.1	989.0	4.4	588.0
2015	23 150.4	978.0	4.2	586.9
2016	23 942.9	949.1	4.0	558.1
2017	27 876.3	1 029.8	3.7	621.9
2018*	32 307.3	1 164.2	3.6	636.9

Барилгын салбарын нэмэгдэл өртгийг сүүлийн 10 жилээр авч үзвэл, 2018 онд хамгийн өндөр түвшинд буюу 1 164.2 тэрбум төгрөгт хүрсэн бол 2009 онд 86.2 тэрбум төгрөгт хүрсэн нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

Харин 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 онд 636.9 тэрбум төгрөгт хүрч 2010 оноос 386.7 (2.5 дахин) тэрбум төгрөгөөр, 2013 оноос 22.7 (3.7%) тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 15.1 (2.4%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.


ЗУРАГ 4. БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН БОДИТ ӨӨРЧЛӨЛТ, хувиар,



## Барилга угсралт, их засварын ажил

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2018 онд 4 009.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 226 190.3 (6.0%) тэрбум төгрөгөөр, 2008 оноос 3 501.6 (7.9 дахин) тэрбум төгрөгөөр, 2013 оноос 2 163.9 (2.2 дахин) тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Барилга угсралт, их засварын ажлын 84.2 хувийг дотоодын, 15.8 хувийг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.

ЗУРАГ 5. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, аймаг, нийслэлээр, тэрбум төгрөгөөр




ХҮСНЭГТ 5. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, дотоод, гадаадын байгууллагаар, тэрбум төгрөгөөр, жил бүрийн эцэст

Он	Барилга угсралт, их засварын ажил	Үүнээс:		
		Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн	Гадаадтай хамтарсан байгууллагын гүйцэтгэсэн	Гадаадын байгууллагын гүйцэтгэсэн
2008	508.2	479.6	33.7	28.6
2009	418.0	373.6	26.0	44.4
2010	463.0	442.7	27.0	20.3
2011	745.0	657.2	15.4	87.8
2012	1 034.1	919.7	56.6	114.4
2013	1 845.9	1719.5	24.9	126.4
2014	2 702.9	2 511.6	48.7	191.2
2015	3 267.4	2 991.5	21.3	208.8
2016	3 356.3	3 030.9	19.7	325.4
2017	3 783.6	3 255.4	93.6	528.2
2018*	4 009.8	3 375.8	26.4	634.0

2018 онд барилга угсралт, их засварын ажлын 335.9 (8.4%) тэрбум төгрөгийн ажлыг нэгдүгээр улиралд, 1.3 (32.8%) их наяд төгрөгийн ажлыг хоёрдугаар улиралд, 1.5 (38.4%) их наяд төгрөгийн ажлыг гуравдугаар улиралд, 819.2 (20.4%) тэрбум төгрөгийн ажлыг дөрөвдүгээр улиралд тус тус гүйцэтгэсэн байна.

ЗУРАГ 6. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, улирлаар, тэрбум төгрөгөөр




### Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил

Дотоодын барилгын байгууллагууд 2018 онд 3 375.8 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг гүйцэтгэсэн байна. Энэ нь өмнөх оноос 120.4 (3.4%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлыг өмчийн хэлбэрээр авч үзвэл, хувийн байгууллагын гүйцэтгэсэн ажил 2018 онд 96.4 хувийг эзэлж байна. Энэ нь 2008 оноос 11.0 пунктээр, 2013 оноос 5.3 пунктээр, өмнөх оноос 1.0 пунктээр тус тус өссөн байна. Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлыг өмчийн хэлбэрээр задалбал, хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2011 оноос эхлэн 90 хувиас давсан байна. Цаашид ч хувийн барилгын байгууллагын гүйцэтгэсэн ажил, нийт барилга угсралт, их засварын ажлын дүнд дийлэнх хувийг эзлэх байдал хэвээр хадгалагдах хандлагатай байна. (Хүснэгт 4)


Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлыг аймгуудаар авч үзвэл, “Оюу толгой”, “Шинэ төмөр зам”, “Олон Улсын шинэ нисэх онгоцны буудал” болон бусад авто замын томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжиж буй

Өмнөговь, Дорноговь, Төв, Завхан аймгуудад бусад аймгуудаас илүү барилга угсралт, их засварын ажил явагдаж байна. (Зураг 8)

ЗУРАГ 7. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, аймаг, нийслэлээр



ЗУРАГ 8. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН БҮТЭЦ, өмчийн хэлбэрээр, 2018




ХҮСНЭГТ 6. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, өмчийн хэлбэрээр

Он	Нийт	Үүнээс:		
		Хувийн байгууллагын гүйцэтгэсэн ажлын хувь	Төрийн өмчийн байгууллагын гүйцэтгэсэн ажлын хувь	Гадаадтай хамтарсан байгууллагын гүйцэтгэсэн ажлын хувь
2008	100.0	85.4	7.6	7.0
2009	100.0	87.7	5.3	7.0
2010	100.0	85.3	8.6	6.1
2011	100.0	91.0	6.7	2.3
2012	100.0	90.3	3.5	6.2
2013	100.0	91.1	7.5	1.4
2014	100.0	95.5	2.5	2.0
2015	100.0	97.7	1.5	0.8
2016	100.0	98.3	1.0	0.7
2017	100.0	95.4	1.7	2.9
2018	100.0	96.4	2.8	0.8

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээг төрлөөр авч үзвэл, орон сууцны барилга 33.2 хувийг, орон сууцны бус барилга 35.9 хувийг, инженерийн байгууламж 28.5 хувийг, их засварын ажил 2.4 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 9. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр, хувиар, жил бүрийн эцэст





Барилга угсралтын ажлыг барилгын төрлөөр авч үзвэл, орон сууцны бус барилга 2018 онд хамгийн их буюу 35.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.5 пунктээр буурсан бол 2008 оноос 18.5 пунктээр, 2013 оноос 17.0 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Орон сууцны барилга нийт барилга угсралт, их засварын ажлын 33.2 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 1.6 пунктээр, 2013 оноос 7.0 пунктээр буурсан бол 2008 оноос 3.3 пунктээр өссөн байна.

Инженерийн байгууламжийн ажил нийт барилга угсралт, их засварын ажлын дүнд 28.5 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 1.9 пунктээр өссөн бол 2008 оноос 10.3 пунктээр, 2013 оноос 8.5 пунктээр тус тус буурсан байна. Харин их засварын ажлын хэмжээ хамгийн бага буюу 2.4 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.2 пунктээр өссөн бол 2008 оноос 11.5 пунктээр, 2013 оноос 1.6 пунктээр тус тус буурсан байна. 2008 онд инженерийн байгууламжийн болон их засварын ажлын хэмжээ 52.7 хувийг эзэлж байсан бол 2018 онд 30.9 хувь болж буурсан нь сүүлийн 10 жилийн хугацаанд орон сууцны болон орон сууцны бус барилга ихээр баригдаж, салбарын бүтцэд томоохон өөрчлөлт, шинэчлэлт гарсныг харуулж байна.

Нийслэлийн хэмжээнд 2018 онд орон сууцны дараах томоохон хорооллууд баригдаж байна. Үүнд:

- ХУД-ийн 15-р хороо, Удирдлагын академийн хойно, Жапан тауны баруун талд 400 айлын 25 давхар орон сууцны барилга
- ХУД-ийн 15-р хороо, Наадам центрийн урд 23 давхар, 782 айлын орон сууцны барилга, Цэнгэлдэх хотхон
- БЗД-ийн 26-р хороо, ҮЦХ-ийн ард Мандала хотхоны 88 айлын 2 блок орон сууцны барилга
- БГД-ийн 1-р хороо, Барс захын чанх ард 12 давхар, 150 айлын орон сууцны барилга
- БГД-ийн 4-р хороо, Алтай хотхоны баруун талд 15 давхар, 210 айлын орон сууцны барилга
- ХУД-т Гарден сити, Хүннү вилла зэрэг томоохон орон сууцны хотхоны барилга угсралтын ажлууд явагдаж байна.

Орон сууцны бус барилгын хувьд, улсын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр эмнэлэг, сургууль, цэцэрлэг, худалдаа, үйлчилгээний барилгууд олноор баригдаж байгаагаас


гадна Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажил эрчимтэй явагдаж байна.

Инженерийн байгууламжийн хувьд, улсын төсвийн хөрөнгө болон гадаадын буцалтгүй зээл, тусламжаар дараах томоохон төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Үүнд:

- Баянхонгор аймгаас Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам
- Завханы Тосонцэнгэл сумаас Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто замын ажил
- Завханы Тэлмэн сумаас Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто замын ажил
- Дорнод аймгийн Петро Чайна Дачин Тамсаг ХХК-ийн 21-р талбайгаас Баянхошуу боомт чиглэлийн 58 км урт хатуу хучилттай авто замын ажил
- Завханы Тосонцэнгэлээс Архангайн Цахир сум хүртэл 127 км авто замын ажил
- Баян-Өлгий аймгийн Толбо сумаас Хашаат чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замын ажил
- Улаанбаатар – Хөшигтийн хөндий чиглэлийн 32.2 км урт, 32.1 метр өргөнтэй, 2 зорчих хэсэг бүхий 6 эгнээтэй, 4 ширхэг гүүрэн байгууламж бүхий хатуу хучилттай хурдны замын ажил гэх мэт


ЗУРАГ 10. БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр, хувиар

**2008**




- Орон сууцны
- Орон сууцны бус
- Инженерийн байгууламж
- Их засварын ажил

**2013**




- Орон сууцны
- Орон сууцны бус
- Инженерийн байгууламж
- Их засварын ажил

**2017**



- Орон сууцны
- Орон сууцны бус
- Инженерийн байгууламж
- Их засварын ажил

**2018**



- Орон сууцны
- Орон сууцны бус
- Инженерийн байгууламж
- Их засварын ажил

**Барилгын байгууллагын ажлын бүлэглэлт**

Гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээг өртгөөр нь бүлэглэн авч үзвэл 500 сая буюу түүнээс дээш өртөгтэй ажил 97.0 хувийг, 101-500 сая төгрөгийн өртөгтэй ажил 2.5 хувийг, 51-100 сая төгрөгийн өртөгтэй ажил 0.3 хувийг, 11-50 сая төгрөгийн өртөгтэй ажил 0.2 хувийг, 10 сая төгрөг хүртэлх өртөгтэй ажил үлдсэн хувийг тус тус бүрдүүлж байна.

**ХҮСНЭГТ 7. БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН БҮЛЭГЛЭЛТ, гүйцэтгэсэн барилга, угсралт, их засварын ажлын хэмжээгээр, хувиар, жил бүрийн эцэст**

Он	Бүгд	10 сая төгрөг хүртэл	10-50 сая төгрөг	50-100 сая төгрөг	100-500 сая төгрөг	500 сая төгрөгөөс дээш
2008	100.0	0.1	0.7	1.4	12.6	85.2
2009	100.0	0.1	0.9	1.4	17.1	80.5
2010	100.0	0.1	1.0	1.9	22.8	74.4
2011	100.0	0.1	0.8	0.9	9.4	88.8
2012	100.0	0.0	0.4	0.8	10.4	88.4
2013	100.0	0.0	0.2	0.5	4.5	94.9
2014	100.0	0.0	0.2	0.4	3.5	95.9
2015	100.0	0.0	0.1	0.3	2.1	97.5
2016	100.0	0.0	0.1	0.2	2.0	97.7
2017	100.0	0.0	0.2	0.3	2.0	97.5
2018	100.0	0.0	0.2	0.3	2.5	97.0

11-50 хүртэлх сая төгрөгийн өртөгтэй ажил 2018 онд 0.7 хувийг эзэлж байсан бол 2018 онд 0.5 пунктээр, 51-100 хүртэлх сая төгрөгийн өртөгтэй ажил 1.4 хувийг эзэлж байсан бол 2018 онд 1.3 пунктээр, 101-500 хүртэлх сая төгрөгийн өртөгтэй ажил 12.6 хувийг эзэлж байсан бол 2018 онд 10.1 пунктээр тус тус буурсан бол 500 сая буюу түүнээс дээш төгрөгийн өртөгтэй ажил 85.2 хувийг эзэлж байсан бол 2018 онд 97.0 хувь буюу 11.8 пунктээр нэмэгдсэн байна.

500 сая буюу түүнээс дээш төгрөгийн өртөгтэй ажил сүүлийн жилүүдэд 90-ээс дээш хувийг эзэлж байна. Үүнийг сүүлийн 5 жилээр 3 бүлэг болгон харуулав. (Хүснэгт 8)

**ХҮСНЭГТ 8. 500 САЯ ТӨГРӨГӨӨС ДЭЭШ ӨРТӨГТЭЙ АЖЛЫН БҮЛЭГЛЭЛТ, хувиар**

Он	Бүгд	500 сая - 1 тэрбум төгрөг	1 - 5 тэрбум төгрөг	5 тэрбум төгрөгөөс дээш
2014	100.0	10.1	42.0	47.9
2015	100.0	7.6	34.6	57.9
2016	100.0	5.3	29.4	65.2
2017	100.0	4.4	23.6	72.0
2018	100.0	6.4	26.1	67.5

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД**

**2017** АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД, хүчин чадлаар **2018**

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН СУРГУУЛЬ, СОЁЛЫН БАРИЛГА, мянган суудлаар

19.1



14.2

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ЭМНЭЛЭГ, орны тоогоор

534



616

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН АВТО ЗАМ, км

376.6



442.4

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, мянган айл

18.7



12.8

### 3. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД

#### Ашиглалтад оруулсан орон сууцны барилга

2008 онд 5.4 мянган айлын орон сууц ашиглалтад оруулсан нь сүүлийн 10 жилийн хугацаанд хамгийн бага хэмжээнд байж, харин 2014, 2015 онуудад 23.8 мянган айлын орон сууц ашиглалтад оруулсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.


2018 онд 12.8 мянган айлын 973.5 тэрбум төгрөгийн өртөг бүхий орон сууцны барилгыг ашиглалтад оруулсан байна. Энэ нь өмнөх оноос 5.9 мянган айлаар буурсан байна.

#### ХҮСНЭГТ 9. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, айлын тоо, өртгөөр

Он	Ашиглалтад оруулсан орон сууц, тэрбум төгрөг	Ашиглалтад оруулсан айлын тоо, мянган айл
2008	270.3	5.4
2009	208.9	6.3
2010	344.5	9.9
2011	387.8	11.3
2012	389.4	11.4
2013	856.9	18.0
2014	634.9	23.8
2015	915.9	23.8
2016	1 432.3	19.1
2017	1 280.9	18.7
2018	973.5	12.8

Улсын хэмжээнд 2018 онд 12 828 айлын орон сууц ашиглалтад орсны 10 599 (82.6%) нь Улаанбаатар хотод, 2 229 (17.4%) нь орон нутагт ашиглалтад орсон байна. Аймгуудаар авч үзвэл, Орхон аймагт хамгийн их буюу 478 айлын орон сууц ашиглалтад орсон нь нийт дүнгийн 3.7%, Дорноговь аймагт 323 орон сууц ашиглалтад орсон нь 2.5%, Дархан-Уул аймагт 215 айлын орон сууц ашиглалтад орсон нь 1.7%-ийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 11. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, айлын тоогоор, аймгаар




ХҮСНЭГТ 10. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД, барилгын төрлөөр, тэрбум төгрөгөөр


Барилгын төрөл	2014	2015	2016	2017	2018
<b>Нийт</b>	<b>1 479.4</b>	<b>1 965.1</b>	<b>2 744.9</b>	<b>2 572.9</b>	<b>4 042.6</b>
Орон сууцны барилга	634.9	915.9	1 432.3	1 280.9	973.5
Орон сууцны бус барилга	315.3	441.8	730.9	869.2	1 432.7
Үйлдвэрийн	13.6	90.0	23.2	321.6	96.5
Худалдаа, үйлчилгээний	96.4	85.4	275.5	164.5	638.7
Эмнэлэг, сургууль, соёлын	114.4	183.3	289.2	271.9	259.5
Бусад	91.0	83.2	143.0	111.1	438.0
Инженерийн барилга, байгууламж	447.7	549.4	516.5	344.2	1 537.5
Эрчим хүчний	103.7	155.9	185.2	87.2	532.1
Холбооны	0.1	1.0	1.8	2.5	18.3
Төмөр зам	-	0.4	-	-	-
Авто зам	250.2	262.3	195.8	156.5	355.0
Гүүр, гүүрэн гарц	9.7	14.0	23.7	21.0	41.3
Далан, суваг, шугам, сүлжээ	68.2	90.0	88.7	57.4	162.7
Бусад (зам, талбайн бусад ажил)	15.8	25.8	21.4	19.5	428.1
Их засварын ажил	81.5	58.0	65.2	78.6	98.9



ЗУРАГ 12. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БАЙРШЛЫН БҮТЭЦ, хувиар




ЗУРАГ 13. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН СУРГУУЛЬ, СОЁЛЫН БАРИЛГА, мянган суудлаар, жил бүрийн эцэст




2018 онд нийт 14.2 мянган суудал бүхий сургууль, соёлын барилга ашиглалтад орсон байна. Энэ нь 2008 оноос 6.3 (79.7%) мянган суудлаар өссөн бол 2013 оноос 5.8 (29%) мянган суудлаар, өмнөх оноос 4.9 (25.7%) мянган суудлаар тус тус буурсан байна. 2008 онд 7.9 мянган суудал бүхий сургууль, соёлын барилга ашиглалтад орсон нь сүүлийн 10 жилийн хамгийн бага үзүүлэлт болж байгаа бол 2014, 2015 онуудад 23.8 мянган суудал бүхий сургууль, соёлын барилга ашиглалтад орсон нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

ЗУРАГ 14. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ЭМНЭЛЭГ, орны тоогоор, жил бүрийн эцэст



2018 онд 616 ор бүхий эмнэлгийн барилга ашиглалтад орсон байна. Эмнэлгийн орны тоо 2008 оноос 370 (2.5 дахин)-аар, 2013 оноос 388 (2.7 дахин)-аар, өмнөх оноос 82 (15.4%)-оор тус тус нэмэгдсэн байна. 2016 онд 1 358 ор бүхий эмнэлгийн барилга ашиглалтад орсон нь сүүлийн 10 жилийн хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

ЗУРАГ 15. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН АВТО ЗАМ, км, жил бүрийн эцэст



2018 онд улсын хэмжээнд 442.4 км авто замыг шинээр ашиглалтад оруулсан нь 2008 оноос 268.4 (2.5 дахин) км-ээр нэмэгдсэн бол 2013 оноос 770.6 (63.5%) км-ээр, өмнөх оноос 65.8 (17.5%) км-ээр тус тус буурсан байна.

Монгол Улсын авто замын сүлжээний нийт урт 2018 оны байдлаар 111.9 мянган км байгаа бөгөөд үүний 9.0 мянган км зам хатуу хучилттай, 101.1 мянган км зам хучлагагүй буюу ердийн болон сайжруулсан хөрсөн зам байгаа бөгөөд авто замын хучилтын төрлийг нийт авто замд эзлэх хувиар авч үзвэл, асфальт бетон зам 8 706.4

(7.8%) км, хайрган зам 1 207.9 (1.1%) км, хөнгөвчилсэн зам 205.2 (0.2%) км, цемент бетон зам 81.7 (0.1%) км, ердийн болон сайжруулсан хөрсөн зам 101.1 (90.3%) мянган км байна<sup>1</sup>.

Монгол улсын авто замын нийт сүлжээнд олон улсын болон улсын чанартай зам 14 918.7 км орон нутгийн чанартай зам 96 125.3 км, тусгай зориулалтын буюу уул уурхайн зориулалттай зам 872.7 км, нийслэлийн авто зам 870 км байна.

2018 оны байдлаар Төв, Дархан-Уул, Орхон, Булган, Сэлэнгэ, Архангай, Өвөрхангай, Говьсүмбэр, Хэнтий, Дундговь, Дорноговь, Баянхонгор, Сүхбаатар, Хөвсгөл, Өмнөговь, Дорнод гэсэн 16 аймгийн төв нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдоод байна. Үлдэж буй баруун 5 аймаг буюу Завхан, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн төвүүдийг нийслэл хоттой холбох ажлын хүрээнд ЗТХЯ нь АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр баруун бүсийн босоо тэнхлэгийн Ховд-Баян-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 189.7 км авто зам, БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто замаар холбох ажлыг зохион байгуулж байна.

---

<sup>1</sup> ЗТХЯ-ны мэдээ

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ  
БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН  
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ**

## БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ 2018



ЦЕМЕНТ, мянган тонн	933.8
БЕТОН ЗУУРМАГ, мянган м3	170.7
СУУРИЙН БЛОК, мянган м3	179.1
УЛААН ТООСГО, сая ширхэг	28.9

### БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД, СУРАЛЦАГЧДЫН ТОО



НИЙТ АЖИЛЛАГЧИД, мянган хүн	67.3
ЭМЭГТЭЙ АЖИЛЛАГЧИД, мянган хүн	9.9
ИНЖЕНЕР, мянган хүн	16.7
АРХИТЕКТУР, ХОТ	
ТӨЛӨВЛӨЛТ, мянган хүн	6.1

### БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН



ДУНДАЖ ЦАЛИН, мянган төгрөг	1 032.7
ЭМЭГТЭЙ АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН, мянган төгрөг	1 056.5

### БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ИМПОРТ




ЦЕМЕНТ, мянган тонн	35.8
БАРИЛГЫН БЛОК, мянган м3	6.4
АРМАТУР, КАТАНКА, мянган тонн	191.8
ХАР ЦААС, мянган тонн	13.8

#### 4. БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ

Барилгын материалын гол бүтээгдэхүүн болох цементийн үйлдвэрлэл 2018 онд 933.8 мянган тонн болж, 2008 оноос 664.5 (3.5 дахин) мянган тонн, 2013 оноос 675.0 (3.6 дахин) мянган тонн, өмнөх оноос 258.6 (38.3%) мянган тонноор тус тус нэмэгджээ. Харин шохой үйлдвэрлэл 2018 онд 58.7 мянган тонн болж, өмнөх оноос 2.5 (4.4%) мянган тонноор, 2008 оноос 3.9 (7.1%) мянган тонноор, 2013 оноос 2.0 (3.5%) мянган тонноор тус тус өссөн байна. Бетон зуурмаг үйлдвэрлэл 2018 онд 170.7 мянган м<sup>3</sup> болж, өмнөх оноос 68.2 (66.5%) мянган м<sup>3</sup>-аар, 2008 оноос 78.8 (85.7%) мянган м<sup>3</sup>-аар тус тус өсөж, харин 2013 оноос 147.1 (46.3%) мянган м<sup>3</sup>-аар буурсан байна<sup>2</sup>.

ЗУРАГ 16. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, жил бүрийн эцэст



<sup>2</sup> Аж үйлдвэрийн салбарын АҮ-1 мэдээ, ҮСХ

ХҮСНЭГТ 11. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр, жил бүрийн эцэст

Он	Цемент, мян.тонн	Бетон зуурмаг мян.м <sup>3</sup>	Шохой мян.тонн	Хөнгөн бетон, мян.м <sup>3</sup>	Суурийн блок мян.м <sup>3</sup>	Хүрмэн блок мян.ш	Улаан тоосго мян.ш	Хөөсөнцөр хавтан, мян.м <sup>3</sup>
2008	269.3	91.9	54.8	36.2	208.6	553.6	28 883.0	34.0
2009	234.8	35.9	43.1	16.7	0.1	387.5	17 951.6	5.3
2010	322.5	36.9	50.2	18.4	0.6	521.3	27 680.9	25.7
2011	425.8	68.9	45.3	29.6	15.8	467.7	31 497.3	39.2
2012	349.3	176.2	68.2	43.7	1.4	873.3	58 880.5	74.8
2013	258.8	317.8	56.7	28.6	0.7	692.2	66 312.4	15.1
2014	411.3	432.6	58.0	24.8	0.8	950.1	58 223.6	11.3
2015	410.1	129.0	52.3	20.0	22.5	633.2	39 617.3	5.8
2016	432.4	75.6	47.6	0.1	67.4	317.5	20 473.2	5.3
2017	675.2	102.5	56.2	3.4	91.5	252.1	22 963.4	31.4
2018*	933.8	170.7	58.7	4.3	179.1	305.9	28 923.3	42.8

Эх үүсвэр: Аж үйлдвэрийн салбарын АҮ-1 мэдээ, ҮСХ

Барилгын зарим нэр төрлийн бүтээгдэхүүний 2018 оны үйлдвэрлэлийг гол нэр төрлөөр авч үзвэл, цемент 933.8 мянган тонн, шохой 58.7 мянган тонн, хүрмэн блок 305.9 мянган ширхэг, бетон зуурмаг 170.7 мян.м<sup>3</sup>, суурийн блок 179.1 мян.м<sup>3</sup>, хөнгөн бетон 4.3 мян.м<sup>3</sup>, улаан тоосго 28.9 сая ширхэг, хөөсөнцөр хавтан 42.8 мян.м<sup>3</sup> тус тус үйлдвэрлэжээ.

ХҮСНЭГТ 12. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ИМПОРТ, жил бүрийн эцэст

Он	Цемент, мян.тонн	Цонхны шил, мян.м <sup>2</sup>	Ширмэн радиатор, тонн	Арматур, катанка, тонн	Галт тэсвэртэй тоосго, блок, хавтан, тонн	Хар цаас, тонн	Зүсмэл модон материал /Банз/ мян.м <sup>3</sup>	Барилгын блок, м <sup>3</sup>
2008	643.3	1 436.6	742.3	18 594.6	5 150.0	11 365.3	8 599.0	-
2009	307.0	963.2	397.3	1 044.3	2 687.6	9 216.2	960.9	-
2010	445.1	923.1	808.0	20 074.3	3 139.1	10 258.4	1 925.3	977.8
2011	785.9	824.9	1 096.5	134 173.2	8 156.4	13 714.3	9 702.0	17 447.5
2012	1 192.3	1 848.4	1 111.8	143 994.6	5 255.4	14 794.9	6 321.2	70 404.2
2013	1 525.6	2 735.1	936.8	246 001.7	4 376.7	13 338.2	18 764.8	71 084.8
2014	1 506.0	2 645.9	797.7	265 336.8	3 147.0	15 357.0	33 528.0	52 813.0
2015	884.3	1 920.6	451.7	172 212.5	5 164.2	12 691.0	13 762.4	21 759.9
2016	252.6	1 534.7	279.8	71 636.9	1 282.6	10 129.1	5 776.3	6 689.9
2017	35.8	1 443.2	312.6	104 160.1	3 544.2	9 178.9	39 891.1	-
2018	35.8	2 379.6	745.4	191 833.9	4 231.2	13 767.8	1 893.4	6 398.8

Эх үүсвэр: ГЕГ-ын импортын мэдээлэл

2018 онд цемент 35.8 мянган тонн, цонхны шил 2 379.6 м<sup>2</sup>, ширмэн радиатор 745.4 тонн, арматур катанка 191.8 мянган тонн, галд тэсвэртэй тоосго, блок, хавтан 4.2 мянган тонн, хар цаас 13.8 мянган тонн, зүсмэл модон материал 1 893.4 мянган метр куб, барилгын блок 6.4 мянган метр кубыг тус тус импортолсон байна.

Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой барилгын материалыг импортоор оруулж ирж байна.

ХҮСНЭГТ 13. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ИМПОРТ, биет хэмжээ, үнийн дүнгээр, 2018 онд

Барааны нэр	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Үнийн дүн, ам.доллар
Цемент	мян.тонн	35.8	2 032.9
Барилгын блок	мян.м <sup>3</sup>	6.4	205.0
Арматур, катанка	мян.тонн	191.8	113 212.0
Хаалга	мян. ширхэг	33.2	2 198.7
Цонхны шил	мян.м <sup>2</sup>	2 379.6	4 923.8
Ширмэн радиатор	мян.тонн	0.7	452.6
Зүсмэл модон материал /Банз/	мян.м <sup>3</sup>	1.9	354.6
Модон хавтан /Эслэг хавтан/	мян.м <sup>2</sup>	2 799.4	9 261.0
Фанер	мян.м <sup>3</sup>	18.1	4 498.5
Хар цаас	мян.тонн	13.8	5 688.9
Галт тэсвэртэй тоосго, блок, хавтан	мян.тонн	4.2	2 450.2
Хуванцар хоолой	мян. ширхэг	5 064.6	14 810.7

Эх үүсвэр: ГЕГ-ын импортын мэдээлэл



**ТАВДУГААР БҮЛЭГ**  
**БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО,**  
**ДУНДАЖ ЦАЛИН, ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ**

**БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧИД 2018**



САЛБАРЫН НИЙТ АЖИЛЛАГЧИД,  
мянган хүн **76.6**

САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН  
НИЙТ ДУНД ЭЗЛЭХ ХУВЬ **6.1**

САЛБАРЫН 1 АЖИЛЛАГЧИД  
НОГДОХ ДНБ, сая төгрөг **7.4**

**БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ЦАЛИН, ХӨЛС**



АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ  
ЦАЛИН, мянган төгрөг **1 032.7**

ЭМЭГТЭЙ АЖИЛЛАГЧДЫН  
ДУНДАЖ ЦАЛИН, мянган  
төгрөг **1 058.5**

**БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ  
ЦАЛИНГИЙН ӨСӨЛТ**



## 5. БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, ДУНДАЖ ЦАЛИН

Улсын хэмжээнд 2018 онд 15 ба түүнээс дээш насны 1 253.0 мянган ажиллагчид байна. Барилгын салбарт улсын хэмжээний нийт ажиллагчдын 76.6 мянган хүн буюу 6.1 хувь нь ажиллаж байна.


Барилгын салбарт ажиллагчдын тоо 2008 оноос 9.8 (14.7%) мянган хүнээр, 2013 оноос 4.2 (5.9%) мянган хүнээр, өмнөх оноос 6.0 (6.1%) мянган хүнээр тус тус нэмэгдсэн байна.

### ХҮСНЭГТ 14. БАРИЛГЫН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧДЫН ТОО, ЖИЛЭЭР

Он	15 ба түүнээс насны ажиллагчдын тоо	Барилгын салбарт ажиллагчдын тоо	Барилгын салбарын ажиллагчдын нийт дүнд эзлэх хувь
2008	1 041 742	66 800	6.4
2009	1 006 285	49 590	4.9
2010	1 033 708	48 758	4.7
2011	1 037 681	51 963	5.0
2012	1 056 441	59 204	5.6
2013	1 103 601	72 350	6.6
2014	1 110 698	81 127	7.3
2015	1 151 223	88 118	7.7
2016	1 147 843	71 485	6.2
2017	1 238 333	70 606	5.7
2018	1 253 023	76 596	6.1

Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа, ҮСХ


### ЗУРАГ 17. БАРИЛГЫН САЛБАРТ 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧДЫН ТОО, МЯНГАН ХҮН



### Барилгын салбарт ажиллагчдын дундаж цалин

Барилгын салбарт ажиллагчдын дундаж цалин 2018 онд дунджаар 1 032.7 мянган төгрөг байгаа бөгөөд эмэгтэй ажилчдын дундаж цалин 1 056.5 мянган төгрөг буюу салбарын дунджаас 23.8 мянган төгрөгөөр дээгүүр байна. Барилгын салбарт ажиллагчдын дундаж цалин 10 жилийн өмнөх буюу 2008 оноос 809.5 (4.6 дахин) мянган төгрөгөөр, 2013 оноос 313.7 (43.6%) мянган төгрөгөөр, өмнөх оноос 180.4 (21.2%) мянган төгрөгөөр тус тус өссөн байна.


ЗУРАГ 18. БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН, мянган төгрөгөөр, жилээр



### Барилгын салбар дахь хөдөлмөрийн бүтээмж

Бүтээмж нь салбарын үр ашигтай байдлыг илэрхийлэх чухал үзүүлэлтийн нэг юм. Барилгын салбарын 1 ажиллагчид ногдох бодит ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, 2018 онд 7.4 сая төгрөг байгаа бөгөөд 2008 оноос 2.3 (44.7%) сая төгрөгөөр өндөр байгаа бол, 2013 оноос 1.1 (12.5%) сая төгрөг, өмнөх оноос 1.4 (15.7%) сая төгрөгөөр, улсын түвшнээс 6.4 сая төгрөгөөр доогуур түвшинд байна. Сүүлийн 10 жилээр авч үзвэл 2012 онд салбарын 1 ажиллагчид ногдох ДНБ-ий хэмжээ 9.6 сая төгрөг буюу хамгийн өндөр түвшинд хүрч байсан байна.

ЗУРАГ 19. БАРИЛГЫН САЛБАР ДАХЬ ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг



### Барилгын салбарын осол

Барилгын салбарт хөдөлмөрийн аюулгүй, эрүүл ахуйн дүрэм, журам хамгийн чухал байдаг. УИХ-аас 2008 онд батлан гаргасан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуульд “... барилга байгууламжийг барьж байгуулах, өргөтгөх, шинэчлэх, машин тоног төхөөрөмж угсрах, суурилуулах, туршилт засвар хийх үйлчилгээ нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна” гэж заасан байдаг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтыг МХЕГ өөрийн үндсэн чиг үүргийн хүрээнд хариуцан ажиллаж байна.

Барилгын салбарт сүүлийн 3 жилд 53 хүн осолдсон бөгөөд үүний 6 (11.3%) нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 15. БАРИЛГЫН САЛБАРТ ОСОЛДОГЧИД, хүйсээр

	2016	2017	2018
Осолдогчид	21	15	17
Үүнээс: Эмэгтэй	2	3	1

Эх үүсвэр. МХЕГ-ын мэдээлэл

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ**

### **ОРОН СУУЦНЫ ҮНЭ, ИПОТЕКИЙН ЗЭЭЛ**

**БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮНЭ,  
төгрөгөөр**

**2018**



ЦЕМЕНТ, 50 кг

9 251

ТООСГО, ширхэг

261

ВАКУМ ЦОНХ, м2

84 134



ПАРКЕТАН ШАЛ, м2

22 340

ПЛИТА, ширхэг

1 748

**ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС**

**УЛААНБААТАР ХОТ**



БАЯНГОЛ ДҮҮРЭГ

100.0

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ

100.4

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

100.6



СҮХБААТАР ДҮҮРЭГ

100.0

ХАН-УУЛ ДҮҮРЭГ

101.1

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

100.4

**ИПОТЕКИЙН ЗЭЭЛ**

**8%**

ШИНЭЭР НЭМЭГДСЭН ЗЭЭЛДЭГЧ,  
мянган хүн

9.3

ЗАСГИЙН ГАЗРААС ШИНЭЭР  
ОЛГОСОН ЗЭЭЛ, тэрбум төгрөг

120.0


## 6. ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС, ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

### Ипотекийн зээл

Төрөөс 2013 оны 6 дугаар сараас орон сууцны ипотекийн 8 хувийн зээлийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь сүүлийн жилүүдэд барилгын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн юм.

Тухайлбал, ипотекийн 8.0 хувийн зээлийн арга хэмжээ хэрэгжүүлж эхэлсэн 2013 оны сүүлийн хагасаас 2017 он хүртэлх хугацаанд ашиглалтад оруулсан орон сууцны тоо эрс нэмэгдэж, харин 2016 оны сүүлээр зээлийн санхүүжилтийг төрөөс түр хугацаагаар зогсоосон нь барилгын салбарын хөрөнгө оруулалтад нөлөөлж, улмаар барилга угсралт, их засварын ажлын хэмжээ болон ашиглалтад оруулсан орон сууцны тоо буурахад нөлөөлсөн байна.

ЗУРАГ 20. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА, ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ТОО, жил бүрийн эцэст



2018 онд 12.8 мянган айл бүхий орон сууцны зориулалттай барилга ашиглалтад оруулсан нь 10 жилийн өмнөх буюу 2008 оноос 7.4 мянган айлаар өссөн хэдий ч 2013 оноос 5.2 мянган айлаар, өмнөх оноос 5.9 мянган айлаар буурсан байна. Мөн шинээр 9.3 мянган иргэн ипотекийн зээлд шинээр хамрагдсан байна.



Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл”-ийн хүрээнд 2015 онд эхний ээлжинд 23 компани 10 364 айлын орон сууцны барилгын ажлыг эхлүүлсэн бол 12-р сарын байдлаар 9 төслийн 1 847 айлын орон сууцанд захиалга авч байна. Төслийн хүрээнд 322 (17%) айлын орон сууц бүрэн ашиглалтад орж, 1 525 (83%) айлын орон сууц ашиглалтад ороогүй буюу барилгын ажил явагдаж байна.

Монгол Улсын Засгийн газар, АХБ-тай хамтран “Иргэдийн орлогод нийцсэн, эко орон сууцны төсөл”-ийг хамтран хэрэгжүүлэхээр болсон. Уг төслийн хүрээнд 2019 онд Улаанбаатар хотод 10 мянган айлын орон сууцыг барихаар төлөвлөж байна. 2018 оны эцсийн байдлаар ипотекийн зээлийн нийт үлдэгдэл 4.4 их наяд төгрөгт хүрч, зээлдэгчдийн тоо 93.9 мянга болсон байна. Үүний 3.3 (75%) их наяд төгрөг нь ЗГОСИЗХ-ийн хүрээнд олгосон зээл, 1.1 (25%) их наяд төгрөг нь хөтөлбөрийн бус зээл байна.


2018 оны эцсийн байдлаар МИК-ын худалдан авах боломжтой 487.0 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл болон 1.0 их наяд төгрөгийн хөтөлбөрийн бус зээл байна<sup>3</sup>.

Ипотекийн зээлийн хөтөлбөрийн санхүүжилтэд зориулж Засгийн газраас 120 тэрбум төгрөгийг, Монголбанкны давуу эрхтэй үнэт цаасны эргэн төлөлтийн санхүүжилтээс 180 тэрбум төгрөгийг 2018 онд тус тус төсөвлөсөн бөгөөд оны эцсийн байдлаар банкуудад нийт 309.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн санхүүжилтийг олгосон байна. ЗГОСИЗХ хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 2013 оноос хойш банкны болон бусад эх үүсвэрийн ипотекийн зээл олголт буурч байсан бол 2018 оны эцсийн байдлаар банкны болон бусад эх үүсвэрээр 411.0 тэрбум төгрөгийн зээл олгосон нь хөтөлбөрийн зээл олголтоос 101 гаруй тэрбум төгрөгөөр их байна.


Нийт ипотекийн зээлдэгчдийн насны бүтцийг харвал, 25-35 насны иргэд хамгийн их буюу 39.0 мянга байна. 2018 оны эцсийн байдлаар манай улсын нийт хүн амын 981.8 (30.3%) мянга нь 18-35 хүртэлх насны залуучууд байгаа бөгөөд үүний 245 (25.0%) мянга нь 20-24 насны, 294.6 (30.0%) мянга нь 25-29 насны залуучууд буюу ойрын жилүүдэд ипотекийн зээлд хамрагдах боломжтой иргэд байна.

<sup>3</sup> Монголын Ипотекийн Корпорацын 2018 оны тайлан

ЗУРАГ 21. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ ОЛГОЛТ,  
тэрбум төгрөг



ЗУРАГ 22. ИПОТЕКИЙН ЗЭЭЛДЭГЧДИЙН  
НАСНЫ БҮТЭЦ, мянган хүн



ЗГОСИЗХ-т зориулж 2019 онд Засгийн газраас 115.0 тэрбум төгрөг, Монголбанкнаас 200.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж байна.

### “Түрээсийн орон сууц” хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газраас “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлж, уг хөтөлбөрийн хүрээнд 1 512 айлын сууцны санг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Буянт-Ухаа II – 564 айл
- Хангай хотхон – 223 айл
- Архангай аймаг – 120 айл
- Дархан-Уул аймаг – 152 айл
- Увс аймаг – 105 айл
- Ховд аймаг – 116 айл
- Хэнтий аймаг, Чингис хот – 120 айл
- Хэнтий аймаг, Бор-Өндөр сум – 10 айл
- Сэлэнгэ аймаг, Мандал сум – 102 айл

Мөн Хөгжлийн банкны санхүүжилтээр орон нутагт 570 айл, Улаанбаатар хотод 972 айл, нийт 1 542 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулсан бөгөөд эдгээр орон сууцыг орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэхээр ажиллаж байна.

## Орон сууцны үнийн индекс


Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт орон сууцны үнэ 2018 оны 4 дүгээр улиралд 2010 оны эцсээс 82.1 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар буурсан бол өмнөх улиралтай харьцуулахад өөрчлөлт ороогүй байна. Орон сууцны үнэ 2018 оны 4-р улиралд өмнөх оны мөн үеэс Сонгинохайрхан дүүрэгт 0.3 хувь, Баянгол, Сүхбаатар дүүргүүдэд 0.1 хувиар буурч, харин Баянзүрх дүүрэгт 0.1 хувь, Хан-Уул дүүрэгт 0.4 хувиар өсөж, харин Чингэлтэй дүүрэгт өөрчлөлт ороогүй байна.

ХҮСНЭГТ 16. УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС, 2018 оны 4-р улирлын байдлаар, төвийн 6 дүүргээр, ашиглалтад оруулсан хугацаагаар, хувиар

Ашиглалтад оруулсан хугацаа	2018 X-XII	2018 X-XII	2018 X-XII
	2010 X-XII	2017 X-XII	2018 VII-IX
	хувь		
<b>Ерөнхий индекс</b>	<b>182.1</b>	<b>99.9</b>	<b>100.0</b>
<b>Хан-Уул</b>	<b>180.6</b>	<b>100.4</b>	<b>100.1</b>
1970 оноос өмнө	184.0	99.9	100.0
1970-2001 он	189.9	100.2	100.2
2001 оноос хойш	168.6	101.1	100.1
<b>Баянзүрх</b>	<b>179.9</b>	<b>100.1</b>	<b>100.1</b>
1970 оноос өмнө	162.6	99.7	100.0
1970-2001 он	189.3	100.1	100.2
2001 оноос хойш	177.8	100.4	99.9
<b>Баянгол</b>	<b>176.4</b>	<b>99.9</b>	<b>100.0</b>
1970 оноос өмнө	166.9	99.8	100.0
1970-2001 он	172.3	99.9	100.0
2001 оноос хойш	189.6	100.0	100.0
<b>Сүхбаатар</b>	<b>196.2</b>	<b>99.9</b>	<b>99.9</b>
1970 оноос өмнө	179.4	99.9	100.1
1970-2001 он	203.4	99.9	100.0
2001 оноос хойш	194.1	100.0	99.8
<b>Чингэлтэй</b>	<b>190.7</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
1970 оноос өмнө	189.0	99.8	100.0
1970-2001 он	193.8	100.0	100.0
2001 оноос хойш	189.0	100.4	100.2
<b>Сонгинохайрхан</b>	<b>177.9</b>	<b>99.7</b>	<b>99.9</b>
1970 оноос өмнө	187.2	99.7	100.0
1970-2001 он	176.8	99.5	99.9
2001 оноос хойш	184.1	100.6	100.6


Тайлбар: Үл хөдлөх хөрөнгө зуучлалын компаниудын мэдээлэлд үндэслэн тооцов. Орон сууцны үнийн зарим мэдээлэл байхгүй тохиолдолд статистикийн орлуулга хийх аргыг ашигласан.

ЗУРАГ 23. ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС, 2018 оны 4-р улирлын байдлаар, хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, нийслэлийн төвийн 6 дүүргээр



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2018 оны 4 дүгээр улиралд 1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнэ төвийн 6 дүүрэгт 0.1-0.3 хувиар буурч, 1970-2001 оны орон сууцных Баянзүрх дүүрэгт 0.1 хувь, Хан-Уул дүүрэгт 0.2 хувиар өсөж, Чингэлтэй дүүрэгт өөрчлөлтгүй, бусад дүүрэгт 0.1-0.5 хувиар буурч, 2001 оноос хойш ашиглалтад оруулсан орон сууцных Баянгол, Сүхбаатар дүүрэгт өөрчлөлтгүй, харин бусад дүүрэгт 0.4-1.1 хувиар өссөн байна.

ЗУРАГ 24. ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС, 2018 оны 4-р улирлын байдлаар, хувиар, өмнөх улиралтай харьцуулснаар, нийслэлийн төвийн 6 дүүргээр



1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнэ 2018 оны 4-р улиралд өмнөх улирлаас Сүхбаатар дүүрэгт 0.1 хувиар өсөж, бусад дүүрэгт өөрчлөлтгүй, 1970-2001 оны орон сууцных Сонгинохайрхан дүүрэгт 0.1 хувиар буурч, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд өөрчлөлтгүй, Хан-Уул, Баянзүрх дүүрэгт 0.2 хувиар өсжээ. 2001 оноос хойш ашиглалтад оруулсан орон сууцны үнэ Баянгол дүүрэгт өөрчлөлтгүй, Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт 0.1-0.2 хувиар буурч, бусад дүүрэгт 0.1-0.6 хувиар өсжээ.

**Барилгын материалын үнэ**

**ХҮСНЭГТ 17. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ЖИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, төгрөгөөр**

Материалын нэр	2015	2016	2017	2018	$\frac{2018}{2017}$ %
Ханын цаас, боодол	11 193	11 339	11 707	10 000	11 000
Цагаан тосон будаг, 1 литр	3 243	3 453	3 596	3 876	4 876
Плита, ширхэг	1 700	1 684	1 659	1 748	2 748
Цемент, 50 кг	9 161	9 386	9 712	9 251	10 251
Тоосго, ширхэг	279	307	296	261	262
Вакум цонх, 1 м <sup>2</sup>	79 517	82 365	85 410	84 134	85 134
Паркетан шал, 1 м <sup>2</sup>	19 840	21 295	21 861	22 340	23 340

Эх үүсвэр: Хэрэглээний үнийн сарын мэдээ, ҮСХ

Барилга угсралтын ажилд түгээмэл хэрэглэгддэг зарим нэр төрлийн бүтээгдэхүүний үнийг өмнөх онтой харьцуулж авч үзвэл, цагаан тосон будгийн үнэ 7.8 хувиар, плитаны үнэ 5.4 хувиар, паркетан шалны үнэ 2.2 хувиар тус тус өссөн бол ханын цаасны үнэ 14.6 хувиар, цементийн үнэ 4.7 хувиар, тоосгоны үнэ 11.8 хувиар, вакум цонхны үнэ 1.5 хувиар тус тус буурсан байна.

**ХҮСНЭГТ 18. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ҮНИЙН ИНДЕКС, 2018 оны 12 дугаар сарын байдлаар**

Материалын нэр	2018 XII	2018 XII
	2017 XII	2018 XI
Ханын цаас, боодол	113.2	100.0
Цагаан тосон будаг, 1 л	114.1	100.0
Плита, ш	102.9	100.0
Цемент, 50 кг	108.4	100.8
Тоосго, ш	93.2	103.8
Вакум цонхны үнэ, 1 м <sup>2</sup>	106.3	100.0
Паркетан шал, 1 м <sup>2</sup>	100.7	100.0

Эх үүсвэр: Хэрэглээний үнийн сарын мэдээ, ҮСХ

**ДОЛООДУГААР БҮЛЭГ**  
**БАРИЛГЫН САЛБАРЫН ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙН**  
**ЧИГ ХАНДЛАГА**

## 7. БАРИЛГЫН САЛБАРЫН ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Барилгын салбарын бүтээн байгуулалт манай улсад төдийгүй дэлхий дахинд идэвхжиж, орчин үеийн хүмүүсийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, инженерийн нарийн ур хийцтэй шийдэл бүхий байгаль орчинд ээлтэй барилга, байгууламж ихээр барих хандлагатай болж байна. Барилгын материал болон түүний үндсэн түүхий эд нь байгаль орчинд ямар нэг сөрөг нөлөөгүй, хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй байх нь хамгийн чухалд тооцогдож байна.

АНУ-ын судалгааны байгууллагаас барилгын салбарын хөгжлийн дараах 9 чиг хандлагыг 2018 онд тодорхойлж гаргасан байна<sup>4</sup>. Үүнд:

1. Барилгын салбарт технологийн дэвшил болон томоохон төслүүд дээр нэгдэх үйл явц өргөжиж байгаа
2. Байгальд ээлтэй, ногоон технологи эрчимжиж байгаа
3. Угсармал болон модуляр барилгын томоохон төслүүд хэрэгжиж байгаа
4. Барилгын материалын зардал өссөөр байгаа
5. Ажиллах хүчний хомсдол үргэлжилж байгаа
6. Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал илүү сайжирч байгаа
7. Барилгын салбар дахь тогтвортой байдал хэвээр хадгалагдаж байгаа
8. Шинэ төслийн менежментийн шийдлүүд шинээр гарч ирж байгаа
9. Барилгын мэдээллийн загварчлал илүү сайжирч байгаа зэргийг тодорхойлжээ.

---

<sup>4</sup> <https://esub.com/10-construction-industry-trends/>

## ДНБ-Д БАРИЛГЫН САЛБАРЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Олон Улсын түвшинд барилгын салбарын үндсэн үзүүлэлтүүдийг аж үйлдвэрийн салбарт оруулж тооцдог байна. Гэхдээ НҮБ-ын Европын эдийн засгийн комиссоос барилгын салбарын ДНБ-д эзлэх хувийг 88 орныг хамруулан 2018 оны байдлаар гаргасан байна.

Тус судалгаагаар ДНБ-д барилгын салбарын эзлэх хувь 2018 оны байдлаар хамгийн дээд түвшин нь Албани улсад 10.4 хувьд хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, дэлхийн улс орнуудад барилгын салбарын эзлэх хувь 10 хувиас бага байгааг харуулж байна.

ДНБ-д барилгын салбарын эзлэх хувь 8.7-10.4 хүртэл хувийг эзэлж байгаа өндөр улс орнууд нь 1990 оноос хойш ЗХУ-аас задарч, зах зээлд шилжсэн Европын улс орнууд болох Албани, Азербайжан, Киргизстан, Молдова, Словак зэрэг орнууд байна.

Манай улсын хувьд барилгын салбарын ДНБ-ий 3.6 хувийг эзэлж байгаа бөгөөд Европын зарим улс орнууд, тухайлбал, Нидерланд (4.8%), Итали (4.7%), Болгар (4.3%), Португал (4.0%), Мальта (3.7%), Ирланд (2.9%) зэрэг улсуудтай ойролцоо түвшинд байгаа юм.


### ХҮСНЭГТ 19. БАРИЛГЫН САЛБАРЫН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ, эхний 10 улсаар, эрэмбээр

№	Улсын нэр	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	Албани	18.2	17.3	14.9	14.6	13.1	11.8	9.9	10.1	10.1	10.5	10.4
2	Азербайжан	7.4	7.7	8.7	8.4	10.7	12.4	13.7	13.1	11.4	10.3	10.3
3	Киргизстан	...	...	5.9	5.4	7.2	7.1	8.3	9.2	9.3	9.8	9.9
4	Молдова	...	...	7.8	7.6	7.9	7.8	8.2	8.3	7.8	8	9.2
5	Словак	9.5	9.7	8.9	8.9	9	7.8	7.9	8.1	7.8	8.2	8.7
6	Монтенегро	7.9	6.6	6.0	5.9	5.6	4.5	4.2	4.5	6.7	8.2	8.2
7	Польш	8.3	8.5	8.5	8.7	8	7.4	7.8	8.0	7.0	7.0	8.0
8	Эстони	9.6	7.1	5.9	6.9	7.3	7	6.2	6.1	6.5	7.1	7.7
9	Армени	28.1	20.4	19.1	14.2	12.8	11.5	10.2	10.3	8.4	7.9	7.3
10	Финланд	6.9	6.8	6.4	6.4	6.6	6.5	6.3	6.4	6.9	7	7.2

Эх үүсвэр: НҮБ-ын Европын эдийн засгийн комиссын 2018 оны тайлан



ЗУРАГ 25. БАРИЛГЫН САЛБАРЫН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ, эхний 10 улсаар



Тайлбар: Монгол Улсыг харьцуулалт хийх зорилгоор нэмж оруулсан.

Тус судалгаанд хамрагдсан 44 орны барилгын салбарын ДНБ-д эзлэх хувийг авч үзвэл дунджаар 6.2 хувьтай байна. Эдгээрээс 19 (43.2%) улс нь ДНБ-д барилгын салбарын эзлэх хувь 4.0-6.0 хувьтай байгаа юм.

## ДҮГНЭЛТ

Барилгын салбарын ажиллагчдын тоо, дундаж цалин жилээс жилд тасралтгүй өсөж байгаа бөгөөд 2018 онд тус салбарт ажиллагчдын дундаж цалин 1 032.2 мянган төгрөг, эмэгтэй ажиллагчдын цалин 1 048.8 мянган төгрөгт хүрсэн байна. Мөн үүнээс гадна барилга угсралт, их засварын ажлын хэмжээ сүүлийн жилүүдэд тасралтгүй өссөөр байна. 2018 онд 12.8 мянган айл бүхий орон сууцны барилга, 442.4 км урт авто зам, 14.2 мянган суудал бүхий сургууль, соёлын барилга, 616 ор бүхий эмнэлгийн барилга тус тус баригдаж ашиглалтад орсон байна. Улсын хэмжээнд сургууль, цэцэрлэгийн болон замын барилга угсралтын ажил сүүлийн 5 жилийн хугацаанд өмнөх 5 жилтэй харьцуулахад эрчимтэй нэмэгдсэн байна.

2013 оноос төрөөс хэрэгжүүлж эхэлсэн ипотекийн жилийн 8 хувийн хүүтэй орон сууцны зээл нь иргэдэд үр өгөөжөө өгч, зээл олгож эхэлснээс хойш 93.9 мянган иргэн хамрагдаж, өөрийн эзэмшлийн орон сууцтай болсон байна. Барилга угсралтын ажил эрчимтэй өрнөж байгаагийн дийлэнх хувь нь нийслэл Улаанбаатар хотод явагдаж байгаа бөгөөд үүнийг даган энгийн орон сууцаас гадна чинээлэг хэрэглэгчдэд зориулсан, тэдний хэрэгцээ шаардлагыг хангах тансаг зэрэглэлийн орон сууцууд олноор баригдаж байна. Мөн орон сууцны бус барилга, ялангуяа худалдаа, үйлчилгээний барилга угсралтын ажил эрчимтэй нэмэгдэж байгаа нь барилга угсралтын ажлын бүтцээс тодорхой харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд төрөөс авч хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөр нь эдийн засагт үр нөлөөгөө шууд болон шууд бусаар өгч байгаа нь уг танилцуулгад дурдагдсан тоон мэдээллээс тодорхой харагдаж байна. Цаашид салбарын тасралтгүй өсөлтийг хангах, тооцоо, судалгаатай төрийн тогтвортой бодлогыг оновчтой үргэлжлүүлэх, шинэлэг төсөл, хөтөлбөрийг боловсруулж үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

- Барилга байгууламж, объектын улирлын мэдээ, ҮСХ
- Хэрэглээний үнийн сарын мэдээ – 2018 , ҮСХ
- Аж үйлдвэрийн салбарын танилцуулга, 2018, ҮСХ
- Тээврийн салбарын танилцуулга, 2018, ҮСХ
- “Монгол Улс 100 жилд” статистикийн эмхэтгэл, 2012, ҮСХ
- Гадаад худалдааны салбарын статистикийн мэдээ – 2018, ҮСХ
- Монголын Ипотекийн Корпорацын жилийн тайлан, 2018, МИК
- Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, 2019, ҮСХ
- [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)
- [www.mik.mn](http://www.mik.mn)
- [www.1212.mn](http://www.1212.mn)
- [www.mnud.gov.mn](http://www.mnud.gov.mn)
- [www.mrtd.gov.mn](http://www.mrtd.gov.mn)
- <https://w3.unece.org/PXWeb/en/CountryRanking?IndicatorCode=8>
- <https://esub.com/10-construction-industry-trends/>
- <https://toli.gov.mn>